



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ



# ГАЗАРЗҮЙ

*ХУВИЛБАР А*

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....


Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....


**САНАМЖ**

- Даалгаврыг 40 минутад хийж гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.


1. Экватортой зэрэгцээ оршдог дэлхийг тойрсон шулууныг зэргэд гэх ба экватороос тухайн цэг хүртэлх зайг градусуар илэрхийлснийг өргөрөг гэнэ. Зэргэдийн шугамуудыг харуулсан зургийг сонгоорой.



2. Аль зурагт дэлхий, нар, сарны хөдөлгөөнийг зөв дүрсэлсэн байна вэ?



3. Зурагт Европ тивийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ?




- A. 7
- B. 6
- C. 5
- D. 4

4. Зурагт уулын ямар төрлийг харуулсан байна вэ?




- A. Атираат уул
- B. Галт уул
- C. Зөрөгт уул
- D. Хөмбөн уул

5. Аль нь зүүн зүгээс салхилж буйг заасан флюгер (салхины чиглэл заагч) вэ?



6. Хамгийн дулаан температурыг хэд дугаартай термометр зааж байна вэ?



A. 1                      B. 2                      C. 3                      D. 4


7. Нил мөрний эрэг дагуу олон сая хүн амтай Кайр, Хартум, Александра зэрэг түүхэн хотууд оршдог. Эдгээр хотууд байршлын хувьд ямар давуу талтай вэ?

- А. Үер усны аюулд өртөх                      В. Усан цахилгаан станц ашиглах  
 С. Хөрсний гулсалт үүсэх                      Д. Элс, хайрга чулуулаг нэмэгдэх

8. Манай улс 2021 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 16.2, нас баралтын түвшин 4.1 байсан бол хүн амын өсөлтийг олоорой.

A. 20.3                      B. 49.3                      C. 12.1                      D. 3.9

9. Нэг өдрийн цаг агаарын зургийг ажиглан хоногийн дундаж температур хэдэн хэм байхыг зөв тооцоолсныг сонгоорой.



A. -3°C                      B. -4°C                      C. -24°C                      D. -30°C

10. Хаяалбар шугамыг ажиглан зөв дүгнэлтийг сонгоорой.




- A. Хаяалбар шугам өмнөд хэсэгтээ хоорондоо хол байгаа учир эгц гадаргатай байна.
- B. Хаяалбар шугам баруун талдаа хоорондоо хол байгаа учир налуу гадаргатай байна.
- C. Хаяалбар шугам хойд хэсэгтээ хоорондоо хол байгаа учир эгц гадаргатай байна.
- D. Хаяалбар шугам зүүн талдаа хоорондоо ойр байгаа учир налуу гадаргатай байна.

11. Миссисипи мөрөн нь Итаска нуураас эх авч 3778 км замыг туулан Мексикийн буланд цутгадаг бол ямар далайн ай савд хамаарахыг тодорхойлоорой.




- A. Номхон далай
- B. Хойд мөсөн далай
- C. Энэтхэгийн далай
- D. Атлантын далай

12. Далайн бүсийн зургаас **бүүдгэр** болон **ёроолын харанхуй** бүсийг хэд хэдийн тоогоор тэмдэглэсэн байгааг тодорхойлоорой.




- A. 4 ба 2
- B. 2 ба 3
- C. 1 ба 4
- D. 3 ба 1

13. Шилмүүст ой дэлхийн аль хэсгээр тархсан байна вэ?







- A. Экваторын бүс орчим
- B. Матарын зам дагуу
- C. Мэлхийн зам дагуу
- D. Арктикийн бүс орчим

14. Япон улс нь газар хөдлөлтийн гамшигт үргэлж өртдөг улсуудын нэг бөгөөд дэлхий дээр болж буй нийт газар хөдлөлтийн 20 орчим хувь нь Япон улсын орчин тойронд болдог гэж үздэг. Япон улсад яагаад газар хөдлөлт их болдог вэ?




- A. Тектоникийн хавтангуудын уулзвар хэсэгт оршдог учир.
  - B. Газар нутгийн хэмжээ багатай, хүн ам ихтэй учир.
  - C. Техник технологийн хөгжил хурдацтай хөгжиж байгаа учир.
  - D. Дэлхийн хамгийн том Евразийн хавтангийн төв хэсэгт оршдог учир.
15. Хэрвээ чи экваторын бүс орчимд буюу Африкийн нэгэн оронд аялалаар явж байгаа гэж үзвэл аль тохиолдол тааралдах боломжтой вэ?
- A. Мөсөн давхаргаар бүрхэгдсэн газар нутагт зочилж нохой чарга хөлөглөн цагаан үнэг, цагаан баавгайг үзэж танилцана.
  - B. Дархан цаазат газруудад зочилж арслан, заан, ирвэс, хирс, одос үхэр, анааш зэрэг ан амьтдыг ойроос ажиглан танилцана.
  - C. Цаст өндөр уулын мөсөн оргилд хүрч, хад асгад нуугдаж, бэлд нь бууж чаддаг цорын ганц амьтан болох цоохор ирвэстэй танилцана.
  - D. “Түмэн тэмээний баяр” үйл ажиллагаанд оролцож тэмээ унах, тэмээтэй парадад жагсах, говь нутгийнхны ахуй соёлтой танилцана.

16. Далайн болон хуурай газрын усны хэсгүүдийн зургийг зөв харгалзуулаарай.

1		А	Голын голдиролд хөндлөн тогтсон мөргөцгөөс унаж буй ус
2		Б	Эргэн тойрон усаар хүрээлэгдсэн хуурай газрын хэсэг
3		В	Хуурай газар руу түрж орсон далай тэнгис, нуурын усны хэсэг
4		Г	Хонхор газар хуримтлагдан тогтсон, голын болон газар доорх усаар тэжээгддэг ус


- А. 1Б,2А,3В,4Г  
 В. 1А,2В,3Г,4Б  
 С. 1В,2Г,3Б,4А  
 D. 1Г,2Б,3В,4А

17. Хоёр хотын уур амьсгалын ерөнхий төрх байдлыг зөв тодорхойлсныг сонгоорой.



- A. А хотын хамгийн халуун температур нь 18°C байхад В хотын хамгийн халуун температур 27°C байна.  
 В. Б хотод 8 сард хамгийн их хур тунадас унасан байхад А хотод 1 сард хамгийн их хур тунадас унасан байна.  
 С. А хот нь халуун чийглэг уур амьсгалтай байхад Б хот нь сэрүүн хуурай уур амьсгалтай байна.  
 D. А хот хур тунадас, температур жигд байхад Б хот температур жигд, хур тунадас хэлбэлзэлтэй байна.

Дараах газарзүйн зургийг ашиглан **18, 19, 20** дугаар даалгаврыг гүйцэтгэнэ үү.



18. Улаанбаатар болон Канберра хот дэлхийн бөмбөрцгийн аль хэсэгт байгааг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.
- Улаанбаатар – баруун хойд, Канберра – баруун өмнөд
  - Улаанбаатар – баруун өмнөд, Канберра – зүүн өмнөд
  - Улаанбаатар – зүүн хойд, Канберра – баруун өмнөд
  - Улаанбаатар – зүүн хойд, Канберра – зүүн өмнөд
19. Зурагт тэмдэглэсэн хоёр хотын газарзүйн солбицлыг зөв тодорхойлсон хувилбарыг сонгоорой.
- Улаанбаатар хот – ХӨ47°, БУ106°; Канберра хот – ХӨ35°, ЗУ149°
  - Улаанбаатар хот – ӨӨ47°, ЗУ106°; Канберра хот – ӨӨ35°, БУ149°
  - Улаанбаатар хот – ХӨ47°, ЗУ106°; Канберра хот – ӨӨ35°, ЗУ149°
  - Улаанбаатар хот – ӨӨ47°, БУ106°; Канберра хот – ХӨ35°, БУ149°
20. Улаанбаатар хотод Лхагва гарагийн 14:00 цаг болж байгаа бол Австралийн Канберра хотод ямар гарагийн, хэдэн цаг болж байгааг зөв тооцоолсон хувилбарыг сонгоорой.
- Мягмар гарагийн 11:00 цаг
  - Лхагва гарагийн 17:00 цаг
  - Лхагва гарагийн 11:00 цаг
  - Пүрэв гарагийн 17:00 цаг

